

“ЗХБС 2018-2023”-ЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

*Мөнгөний зах, банк хоорондын захын дэд бүтцийн
идэвхжил ба валютын ханшийн зохицуулалт*

Илтгэгч: НУСЗЗГ-ын захирал А.Энхжин

Улаанбаатар хот
2018 оны 11 дүгээр сарын 16



Ханшийн хөдөлгөөнд тогтмол мониторинг хийж, улирал бүр мэдээлнэ.

ЗГ олон улсын зах зээл дээр бонд арилжаалахад Монголбанкнаас дэмжлэг үзүүлж, шаардлагатай мэдээллээр ханган хамтарч ажиллах.

ГВУН-ийг нэмэгдүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, батлуулах.

Мөнгөний захыг идэвхжүүлэх, дэд бүтцийг хөгжүүлэх чиглэлээр олон улсын байгууллагуудаас техник туслалцаа авч, өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх.

Банкуудад урт хугацаат санхүүжилт олгох байнгын хэрэгслийн талаар санал боловсруулж, шийдвэрлүүлэх.

Урт хугацаат санхүүжилтийн хэрэгслийн мөнгөний зах, хүүгийн түвшинд нөлөөлөх нөлөөллийг үнэлж, шаардлагатай тохиолдолд өөрчлөлт оруулах, зогсоох.

Валютын ханшийн эрсдэлийг хаах санхүүгийн үүсмэл хэрэгслийн эрх зүйн орчныг бүрдүүлэх, дэд бүтцийг хөгжүүлэх.

Валютын ханшид богино хугацааны огцом хэлбэлзэл үүсэхээс сэргийлж, шаардлагатай тохиолдолд захын илүүдэл эрэлт, нийлүүлэлтийг тэнцвэржүүлэх арга хэмжээ авна.

Банк хоорондын захын богино хугацааны хүүг бодлогын хүүтэй ойр хадгалах, бодлогын хүүний шилжих механизмыг сайжруулах зорилгоор хүүний коридорыг банк хоорондын захын идэвхжилтэй уялдуулан тухай бүр өөрчлөх.

Улсын гадаад өрийн үйлчилгээний нарийвчилсан хуваарь, санхүүжилтийн төлөвлөгөөг МБ, СЯ хооронд тогтмол шуурхай солилцох дэд бүтцийг сайжруулж, нөөцийн удирдлагад ашиглах.

	Ханшийн хөдөлгөөнд тогтмол мониторинг хийж, улирал бүр мэдээлнэ.	Мөнгөний захыг идэвхжүүлэх, дэд бүтцийг хөгжүүлэх чиглэлээр олон улсын байгууллагуудаас техник туслалцаа авч, өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх.
Үндэслэл	Валютын ханш болон түүнд нөлөөлөгч хүчин зүйлсийн мэдээллийг УИХ-д тогтмол хүргүүлснээр хууль тогтоогчид эдийн засгийн нөхцөл байдлын талаарх ойлголтыг тухай бүр авснаар, төрийн бодлого шийдвэрүүд уялдаатай, оновчтой байх нөхцөл болно.	Санхүүгийн зах зээлийн дэд бүтэц сул байгаагаас шалтгаалан зах зээл үр ашигтай ажиллахгүй байх, зах зээлд тодорхой бус байдал бий болох явдлыг бууруулах шаардлагатай байгаа.
Явц	Монголбанк улирал бүр УИХ-д төгрөгийн ханшийн төлөв, ханшийн өөрчлөлтөд нөлөөлсөн хүчин зүйлсийн тухай мэдээлэл хүргэн ажиллаж байна.	Валютын захын дэд бүтцийг хөгжүүлэх чиглэлээр Швейцарийн хөгжлийн агентлагаас техник туслалцаа авч, өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Мөн валютын захын нэгдсэн платформ бий болгох,

	<p>Валютын ханшийн эрсдэлийг хаах санхүүгийн үүсмэл хэрэгслийн эрх зүйн орчныг бүрдүүлэх, дэд бүтцийг хөгжүүлэх.</p>	<p>ГВУН-ийг нэмэгдүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, батлуулах.</p>
<p>Үндэслэл</p>	<p>Санхүүгийн үүсмэл хэрэгслийн хэрэглээ нэмэгдсэнээр зах зээл дэх тодорхой бус байдал буурч, валютын ханшийн хэлбэлзэл багасах нөлөөтэй.</p>	<p>ГВУН-ийг нэмэгдүүлснээр Монгол Улсын эдийн засгийн гадаад эдийн засгийн сөрөг нөлөөлөлд өртөх эрсдэл буурч, төгрөгийн ханшийн хэлбэлзэл бага байх баталгаа болно.</p>
<p>Явц</p>	<p>Банк хоорондын валютын үүсмэл хэрэгслийн ерөнхий гэрээний төслийг МБ-наас боловсруулаад байна. МХБ-ноос санал авч эцэслэн батална. Ингэснээр зах зээлд энэ төрлийн хэлцлийн идэвхжил нэмэгдэнэ гэж үзэж байгаа.</p>	<p>Монголбанкнаас дотоодоос худалдан авах алтны хэмжээг нэмэгдүүлэх, дотоодын зах зээлээс гадаад валютыг ханшид дарамт багатай байхуйцаар худалдан авахыг зорьж байгаа. Төлөвлөгөөг боловсруулахаар судалж байна.</p>

Саналыг domex@mongolbank.mn хаягаар хүлээн
авахдаа таатай байх болно.

**Анхаарал хандуулсанд
баярлалаа**

Bank of Mongolia

Баянгол-3, 15160 Улаанбаатар 46, Mongolia

Tel: +976-11-323391 Fax: +976-11-327086

<http://www.mongolbank.mn>